



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/252

Улиастай

Тусламж үзүүлэх тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Иргэдээс ирүүлсэн өргөдөл хүсэлтийг үндэслэн тусламж шаардлагатай байгаа иргэдэд 13,000,000 (арван гурван сая) төгрөгийн тусламж үзүүлсүгэй.

2.Тусламж үзүүлэх иргэдийн нэрсийн жагсаалт мөнгөн дүнг хавсралтаар баталсугай.

3.Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Т.Рэнчинванжил)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Чадраабал)-т даалгасугай.

ДАРГА  Т.ӨТӨРБЭЯАР



Захирамж-2023

3109010811